



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Г Эрүүл мэндийн байгууллагуудыг
хүлээн авах тухай

Эрүүл мэндийн яам, Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар Төмөр Зам” нийгэмлэгийн хооронд 2011 оны 3 сарын 30-ний өдөр байгуулсан Санамж бичигт заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор, “УБТЗ” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Ерөнхий хорооны 2011 оны 12 сарын 26-ний өдрийн 5 дугаар хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар Төмөр Зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн харьяанд үйл ажиллагаа явуулдаг Сэлэнгэ аймгийн Зүүнхараа, Дорноговь аймгийн Сайншанд болон Замын-Үүд, Говьсүмбэр аймгийн Чойрын нэгдсэн эмнэлгүүдийг Эрүүл мэндийн яамны харьяанд хүлээн авсугай.

2. Эрүүл мэндийн байгууллагуудыг хүлээн авч байгаатай холбогдуулан орон нутгийн өмчид бүртгэж авах, үйлчлэх хүрээний хүн амд эмнэлгийн тусlamж, үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэх, эмч, эмнэлгийн ажилчдын ажлын ачаалалыг тэнцвэржүүлэх, тэдний ажиллах нөхцөл, боломжийг хангах талаар оновчтой зохицуулалт хийж ажиллахыг Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ж.Од, Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Г.Энхцэцэг, Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Б.Цэцэгмаа нарт тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай зохицуулалтыг хийн ажиллахыг Стратегийг бодлого, төлөвлөлтийн газар (С.Энхболд), Санхүү хөрөнгө оруулалтын газар (Н.Түмэндээмбэрэл), Эмнэлгийн тусlamжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Гончигсүрэн)-т тус тус үүрэг болгосугай.



С.ЛАМБАА

080012